

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НДШ	Нийгмийн Даатгалын Шимтгэл
ХХОАТ	Хувь Хүний Орлогын Албан Татвар

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн хаалтын санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн хаалтын санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
3.Аудитын тайлан	11
3.1. Ерөнхий зүйл	11
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	11
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	12
3.4. Материаллаг байдал.....	12
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	12
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт.....	13
3.7. Шилэн дансны мэдээлэл	14
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
3.9. Аудитын илрүүлэлт	14
Залруулсан алдаа.....	14
Аудитын зөвлөмж	14
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	14



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

УЛААНБААТАР-МАНДАЛГОВИЙН
ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ АГААРЫН
ШУГАМ, ДЭД СТАНЦ БАРИХ ТӨСӨЛ,
ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ
Ч.БАТЗОРИГ ТАНАА

2024.02.25 № 07/592
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй санал дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улаанбаатар-Мандалговийн Цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих төслийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх хаалтын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улаанбаатар-Мандалговийн Цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих төслийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх хаалтын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга илэрхийлсэн толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Төслийн нийт санхүүжилтийг 119.0 сая ам.доллараар хэрэгжүүлэхээр төлөвлөн БНХАУ-ын ЭКЗИМ банк, Сангийн яамны хооронд санхүүжилтийн тусгайлсан гэрээ байгуулсан бөгөөд энэхүү гэрээгээр нийт санхүүжилтийн 95 хувь (113.05 сая ам.доллар)-ийг ЭКЗИМ банк, 5 хувь (5.95 сая ам.доллар)-ийг Монголын тал гаргахаар шийдвэрлэсэн байна.

Төсөл анх хэрэгжиж эхэлсэн 2017 оноос 2019 он дуусталх хугацаанд нийт 105.8 сая ам.доллар буюу 272,350,943.3 мянган төгрөгийн санхүүжилт олгогдож зарцуулагдсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн хаалтын санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн хаалтын санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	88,896,664,225.43	-
31	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	-	-
33	АВЛАГА	68,424,800.26	-
33300	Татаас санхүүжилтийн авлага	18,602,579.82	-
335	Бусад авлага	49,822,220.44	-
3351	Байгууллагаас авах авлага	49,822,220.44	-
36	НӨӨЦИЙН БАРАА	88,828,239,425.17	-
36800	Бусад эргэлтийн хөрөнгө	88,828,239,425.17	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	10,992,681.52	-
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	10,992,681.52	-
392	Биет хөрөнгө	10,464,681.60	-
39205	Машин, тоног төхөөрөмж	10,660,500.00	-
39206	Хуримтлагдсан элэгдэл	(3,198,150.18)	-
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	4,189,300.00	-
39208	Хуримтлагдсан элэгдэл	(1,186,968.22)	-
393	Биет бус хөрөнгө	527,999.92	-
39301	Програм хангамж	880,000.00	-
39302	Хасагдуулга	(352,000.08)	-
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	88,907,656,906.95	-
4	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	68,424,800.26	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	68,424,800.26	-
413	Өглөг	53,256,945.00	-
41310	Ажиллагчидтай холбогдсон өглөг	35,256,945.00	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	18,000,000.00	-
41360	Бусад өглөг	15,167,855.26	-
41363	Татварын өглөг	5,942,997.00	-
41364	НДШ Өглөг	9,224,858.26	-
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	88,839,232,106.69	-
51	Засгийн газрын хувь оролцоо	88,839,232,106.69	-
51200	Хуримтлагдсан үр дүн	88,839,232,106.69	-
51210	Өмнөх үеийн үр дүн	171,838,646.33	-
51220	Тайлант үеийн үр дүн	88,667,393,460.36	-
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	88,907,656,906.95	-

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	89,110,163,200.61	20,869,501,932.52
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	88,913,894,500.61	20,708,057,932.52
120	Нийтлэг татварын бус орлого	88,913,894,500.61	20,708,057,932.52
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	88,913,894,500.61	20,708,057,932.52
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос	79,822,220.44	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос	5,832,855.00	10,071,279.56
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	88,828,239,425.17	20,697,986,652.96
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	196,268,700.00	161,444,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	196,268,700.00	161,444,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	196,268,700.00	161,444,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	442,769,740.25	174,661,239.64
21	УРСГАЛ ЗАРДАЛ	442,769,740.25	174,661,239.64
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	383,702,290.25	164,524,831.08
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	269,644,881.00	121,680,000.00
210101	Үндсэн цалин	269,644,881.00	121,680,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,976,503.25	15,150,960.00
2103	Байрны түрээс	57,000,000.00	9,000,000.00
210304	Байрны түрээс	57,000,000.00	9,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,011,594.19	2,547,911.00
210401	Бичиг хэрэг	1,453,000.00	
210402	Тээвэр, шатахуун	885,000.00	1,594,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,183,094.19	953,911.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,490,500.00	
2107	Томилолт, зочны зардал	13,226,600.00	3,000,000.00
210702	Дотоод албан томилолт	13,226,600.00	3,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,696,751.73	10,000,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,664,500.00	
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		10,000,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	32,251.73	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,145,960.08	3,145,960.08
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	3,145,960.08	3,145,960.08
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	59,067,450.00	10,136,408.56
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	59,067,450.00	10,136,408.56
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	59,067,450.00	10,136,408.56
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	88,667,393,460.36	20,694,840,692.88

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	89,219,123,476.91	20,937,926,732.78
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	89,022,854,776.91	20,776,482,732.78
120	Нийтлэг татварын бус орлого	89,022,854,776.91	20,776,482,732.78
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	89,022,854,776.91	20,776,482,732.78
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	30,000,000.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,832,855.00	78,496,079.82
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	158,782,496.74	
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	88,828,239,425.17	20,697,986,652.96
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	196,268,700.00	161,444,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	196,268,700.00	161,444,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	196,268,700.00	161,444,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	390,884,051.74	239,940,079.82
21	УРСГАЛ ЗАРДАЛ	390,884,051.74	239,940,079.82
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	313,214,021.92	229,803,671.26
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	240,367,826.00	172,056,100.26
210101	Үндсэн цалин	240,367,826.00	172,056,100.26
2102	Ажил олгогчоос НДШ	12,911,250.00	15,199,660.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	39,000,000.00	27,000,000.00
210304	Байрны түрээс	39,000,000.00	27,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,011,594.19	2,547,911.00
210401	Бичиг хэрэг	1,453,000.00	
210402	Тээвэр, шатахуун	885,000.00	1,594,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,183,094.19	953,911.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,490,500.00	
2107	Томилолт, зочны зардал	13,226,600.00	3,000,000.00
210702	Дотоод албан томилолт	13,226,600.00	3,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,696,751.73	10,000,000.00
210801	БГБНАУ-ий төлбөр хураамж	1,664,500.00	
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		10,000,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын хураамж	32,251.73	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	77,670,029.82	10,136,408.56
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	77,670,029.82	10,136,408.56
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	77,670,029.82	10,136,408.56
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	88,828,239,425.17	20,697,986,652.96
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	-

5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	88,828,239,425.17	20,697,986,652.96
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	88,828,239,425.17	20,697,986,652.96
2200	Дотоод эх үүсвэрээр	88,828,239,425.17	20,697,986,652.96
220001	Барилга байгууламж	88,828,239,425.17	20,697,986,652.96
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(88,828,239,425.17)	(20,697,986,652.96)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2019 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл			171,838,646.33	171,838,646.33
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл			171,838,646.33	171,838,646.33
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт			-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт			-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз			-	-
Тайлант үеийн үр дүн			88,667,393,460.36	88,667,393,460.36
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			88,839,232,106.69	88,839,232,106.69
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			109,526,226,078.13	109,526,226,078.13
Дахин илэрхийлсэн үлдэгдэл			88,839,232,106.69	88,839,232,106.69
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт			-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт			(7,846,721.44)	(7,846,721.44)
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз			(109,526,226,078.13)	(109,526,226,078.13)
Тайлант үеийн үр дүн			20,694,840,692.88	20,694,840,692.88
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	20,859,430,652.96	20,859,365,523.96	65,129.00
УРСГАЛ ЗАРДАЛ	161,444,000.00	161,378,871.00	65,129.00
БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	161,444,000.00	161,378,871.00	65,129.00
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	121,680,000.00	121,631,300.00	48,700.00
Үндсэн цалин	121,680,000.00	121,631,300.00	48,700.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15,210,000.00	15,199,660.00	10,340.00
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	15,210,000.00	15,199,660.00	10,340.00
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,000,000.00	9,000,000.00	-
Байрны түрээс	9,000,000.00	9,000,000.00	-
Хангамж, бараа материалын зардал	2,554,000.00	2,554,000.00	-
Тээвэр, шатахуун	1,594,000.00	1,594,000.00	-
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	960,000.00	960,000.00	-
Томилолт, зочны зардал	3,000,000.00	3,000,000.00	-
Дотоод албан томилолт	3,000,000.00	3,000,000.00	-
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,000,000.00	10,000,000.00	-
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	10,000,000.00	10,000,000.00	-
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	20,697,986,652.96	20,697,986,652.96	-
Дотоод эх үүсвэрээр	20,697,986,652.96	20,697,986,652.96	-
Барилга байгууламж	20,697,986,652.96	20,697,986,652.96	-
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	20,859,430,652.96	20,859,365,523.96	65,129.00
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	161,444,000.00	161,378,871.00	65,129.00
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	20,697,986,652.96	20,697,986,652.96	-
Урьд оны үлдэгдлээс санхүүжих			
Гадаадын санхүүгийн зээлийн эх үүсвэрээс	20,697,986,652.96	20,697,986,652.96	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл			

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Улаанбаатар-Мандалговийн Цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих төслийн 2020 оны хаалтын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Ч.Батзориг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 28-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Үндэсний аудитын газар болон Нийслэл-Аудит ХХК-ийн захирал Т.Сугарсүрэн нарын хооронд байгуулсан санхүүгийн тайлангийн аудитад шинжээч ажиллуулах гэрээний дагуу Нийслэл-Аудит ХХК-ийн захирал, аудитор Т.Сугарсүрэн, аудитор Л.Ганзориг нар хариуцаж хэрэгжүүлэв.

2020 оны хаалтын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Нийслэл-Аудит ХХК-д 2021 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр хүргүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 458 дугаар тогтоолоор Улаанбаатар-Мандалговийн цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцыг барих төслийг БНХАУ-ын “Экспорт-Импорт” банкны нэг тэрбум ам.долларын зээлийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд хэрэгжүүлэхээр баталж, ерөнхий хэлэлцээрийн дагуу БНХАУ-ын Засгийн газраас Монгол улсад олгож буй экспортын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Улаанбаатар-Мандалговь цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих” төслийг хэрэгжүүлэхээр болж Сангийн сайдын 2017 оны 105 дугаар тоот тушаалаар уг төслийг хариуцах төслийн нэгжийг байгуулсан.

Төслийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Өмнөд бүсийн эрчим хүчний хангамжийг найдвартай болгох;
- Оюутолгой, Таван толгой, Цагаансуварга болон бусад уурхайн орд газруудыг дотоодын эрчим хүчээр хангах боломжийг бүрдүүлэх;
- Урд хөршийн өсөн нэмэгдэж буй эрчим хүчний хэрэгцээг хангах, цахилгаан эрчим хүч экспортлох нөхцлийг бүрдүүлэх;

Төслийн нийт санхүүжилтийг 119.0 сая ам.доллараар хэрэгжүүлэхээр төлөвлөн БНХАУ-ын ЭКЗИМ банк, Сангийн яамны хооронд санхүүжилтийн тусгайлсан гэрээ байгуулсан бөгөөд энэхүү гэрээгээр нийт санхүүжилтийн 95 хувь (113.05 сая ам.доллар)-ийг ЭКЗИМ банк, 5 хувь (5.95 сая ам.доллар)-ийг Монголын тал гаргахаар шийдвэрлэсэн.

Энэхүү төслийн гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтад нэр бүхий 3 компанийг оролцуулахыг БНХАУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамнаас Сангийн яаманд санал хүргүүлсэний дагуу гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсэг байгуулагдаж, сонгон шалгаруулалтыг зохих хууль, журмын дагуу явуулж, “ТВЕА” компани шалгарч, барилга угсралтын ажил гүйцэтгэх гэрээг 2016 оны 07 дугаар сарын 06-ны өдөр ЭХА-006/16 тоот гэрээг байгуулсан байна.

Төслийн хүрээнд дараах ажлуудыг хийхээр төлөвлөж, гүйцэтгэсэн байна. Үүнд:

- Төслийн хөрөнгөөр шинээр 220/110/35кВ-ын хүчин чадалтай Мандалговь дэд санцыг барьж дуусган, Тавантолгой болон Оюутолгой дэд станцуудыг 220/110/35 кВ-ын 2*125 МВА хүчин чадалтай болгон өөрчилсөн.
- Улаанбаатар Мандалговийн чиглэлд 330кВ-ын овортой 220кВ-ын 249 км урт цахилгаан дамжуулах агаарын шугам барьж дуусгасан.

2017 оны 10 дугаар сараас эхэлж, 2020 оны 8 дугаар сарыг хүртэл үргэлжилж, төслийн ажлыг гүйцэтгэн ашиглалтад хүлээлгэн өгөхөөр бэлэн болсон ч дэлхий нийтээр тархсан КОВИД19 цар тахлын нөлөө, түүнтэй холбоотойгоор Монгол улс дотооддоо гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн, хэд хэдэн удаагийн хөл хорионы дэглэм тогтоосон зэргээс хамаарч уг төслийг улсын комисст хүлээлгэж өгөх асуудал хойшлогдсоор өнөөг хүрсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд томоохон өөрчлөлт ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Төсөл нь 2020 оны санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Эрчим хүчний яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар 2020 онд харьяа орон нутаг дахь тус төслийн нэгжийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 174,661.2 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 3,493.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Тус төслийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 88,907,656.9 мянган төгрөгөөр буюу 100 хувиар буурсан. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бусад эргэлтийн хөрөнгө, үндсэн хөрөнгийн данс байна. Энэ нь төслийн хэрэгжих хугацаа дуусч байгаатай холбоотой.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	68,424.8	-	(68,424.8)
Бусад эргэлтийн хөрөнгө	88,828,239.4	-	(88,828,239.4)
Үндсэн хөрөнгө	10,992.7	-	(10,992.7)

Нийт хөрөнгө	88,907,656.9	-	(88,907,656.9)
Өр төлбөр	68,424.8	-	(68,424.8)
Өмнөх үеийн үр дүн	88,839,232.1	-	(88,839,232.1)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	88,907,656.9	-	(88,907,656.9)

Авлага дансны үлдэгдэл 68,424.8 мянган төгрөгөөр буурсан нь Сангийн яамнаас авах 18,602.6 мянган төгрөгийн өмнөх оны санхүүжилтийн үлдэгдэл, мөн Эрчим хүчний хөгжлийн төвийн өмнөх оны тооцооны үлдэгдэл 49,822.2 мянган төгрөг тайлант хугацаанд барагдсантай холбоотой ажээ.

2019 онд Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Экспорт-Импортын банкны хөнгөлттэй зээлийн ашиглалт болох 88,828,239.4 мянган төгрөгийг санхүүжилтийн орлогоор хүлээн зөвшөөрч, бусад эргэлтийн хөрөнгөд тусгасан дансны үлдэгдэл мөн дүнгээр буурсан нь төслийн хаалтын санхүүгийн тайлан бэлтгэж өмнөх үеийн үр дүн рүү хаасантай холбоотой.

Үндсэн хөрөнгө данс 10,992.7 мянган төгрөгөөр буурсан нь төсөл бүрэн хэрэгжиж хаалтын тайлан гаргаж байгаатай холбогдуулан төслийн нэгжийн хөрөнгийг шилжүүлэх хүсэлтийн дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас 2020 оны А-1/2275 тоот албан бичгийн дагуу Эрчим хүчний яаманд шилжүүлсэнтэй холбоотой.

Өр төлбөр дансны үлдэгдэл 68,424.8 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны 35,256.9 мянган төгрөгийн хуримтлагдсан цалин, 9,224.9 мянган төгрөгийн өмнөх оны НДШ-ийн өр, 5,943.0 мянган төгрөгийн ХХОАТ-ын өмнөх оны үлдэгдэл зэрэг өмнөх оны түрээс, холбогдох ХХОАТ-ын суутгалын хамт нийт 18,000.0 сая төгрөгийн төлбөрийг тайлант хугацаанд бүрэн барагдуулсантай холбоотой байна.

Өмнөх үеийн үр дүн дансны үлдэгдэл 88,839,232.1 мянган төгрөгөөр буурсан нь төслийн нэгжид бүртгэсэн өмнөх жилийн санхүүжилтийн орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэн хөрөнгийг төслийн нэгжийн хаалтын тайлан бэлтгэж байгаатай холбоотойгоор хааснаас шалтгаалжээ.

2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 68,240,661.3 мянган төгрөгөөр буюу 77.0 хувиар буурсан байна. Энэ нь төсөл хэрэгжиж дууссантай холбоотойгоор гадаад санхүүжилтийн ашиглалт энэ хэмжээгээр буурсантай холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 219,177.5 мянган төгрөгөөр буюу 2.3 дахин буурсан байна. Төслийн удирдах хорооны 2020 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн хурлаар төслийн барилга угсралтын ажлын гэрээний хугацааг сунгагдсантай холбогдуулан үйл ажиллагааны зардлын төлөвлөгөөг нэмэлтээр баталж ажиллах бүрэлдэхүүнийг багасгасан нь тайлант хугацаанд цалингийн болон НДШ-ийн зардал буурах үндсэн шалтгаан болсон. Тайлант хугацааны ажлын гүйцэтгэлийн хувь буурснаас ажлын гүйцэтгэлээр тавих хяналтын тоо багассан, КОВИД19 цар тахлын нөлөө зэргээс хамаарч томилолтын зардал буурсан байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 20,878,033.2 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 136,890.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 20,878,033.2 мянган төгрөгөөр баталсан байна. Жил бүрийн гадаад санхүүжилтийн зээлийн эх үүсвэрийн ашиглалттай холбоотойгоор жил бүрийн санхүүжилтийн төлөвлөгөө нь өөр өөр байдаг. Тиймээс тайлант хугацааны санхүүжилтийн төлөвлөгөө нь өмнөх жилийн гадаад эх үүсвэрээс санхүүжүүлэх төлөвлөгөөнөөс материаллаг хэмжээний зөрүүтэй байх боломжтой.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төслийн нэгжийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 1 арга хэмжээг санхүүжүүлэхээр 20,859,430.7 мянган төгрөгийн төсөв баталснаас 161,444.0 мянган төгрөгийг улсын төсвөөс, 20,697,986.7 мянган төгрөгийг гадаад санхүүгийн зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 161,444.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, гадаад зээлийн эх үүсвэрээр 20,697,986.7 мянган төгрөг, нийт 20,859,430.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 161,378.9 мянган төгрөгийг, төслийн хөрөнгийн зардалд 20,657,471.7 мянган төгрөгийг тус тус зарцуулж 65.1 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 20,859,430.7 мянган төгрөг буюу 100 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 148 мэдээллээс хугацаандаа оруулсан 108 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроосон 38 мэдээлэл, байршуулаагүй мэдээлэл байхгүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тус төслийн нэгжийн өмнөх санхүүгийн тайлангийн аудит нь Эрчим хүчний яамны түүвэр аудитад хамрагдсан бөгөөд зөвлөмж өгөгдөөгүй байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар алдаа зөрчил илрээгүй.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай холбоотой залруулга хийдээгүй болно.

Аудитын зөвлөмж

Аудитаар алдаа зөрчил илрээгүй тул менежментийн захидал болон зөвлөмж өгөгдөөгүй.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Тус төслийн нэгжийн төсөл хэрэгжих хугацаа дуусч хаалтын тайлан гаргаж байгаа ч КОВИД19 буюу цар тахлын улмаас хэрэгжүүлж буй үйл ажиллагаа зэргээс хамаарч Улсын

комисс ажиллаагүй шалтгааны улмаас хөрөнгө шилжүүлэх, хөрөнгө хүлээн авах асуудал бүрэн шийдвэрлэгдээгүй байна.